ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан -АЗЗА ТӨХК-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ЗАА-2021/03/СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай хот

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Бат-ундраа

Утас: 99993365 Цахим хаяг:bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг.

Утас: 99019467 Цахим хаяг: Khash_aud@yahoo.com

Ахлах Аудитор: Б.Дагвасүрэн.

Утас:99014227 Цахим хаяг: b_dagvaa@yahoo.com

Завхан-АЗЗА ТӨХК

Утас: 95009536,90099660

Цахим хаяг:zavhan.azza2019@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан....6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан....7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
4 ....8
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ....8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан ....8
3.Аудитын тайлан....9
3.1. Ерөнхий зүйл ....9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ....9
3.4. Материаллаг байдал ....10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....10
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....12
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа ....13
3.8. Шилэн дансны мэдээлэл.... **Error! Bookmark not defined.**
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....17
3.10. Аудитын илрүүлэлт.... **Error! Bookmark not defined.**
Залруулсан алдаа.... **Error! Bookmark not defined.**
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .... **Error! Bookmark not defined.**
4. Менежментийн захидал .... **Error! Bookmark not defined.**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .... **Error! Bookmark not defined.**

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

“ЗАВХАН АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИАРАЛ Г.БАТТУЛГА-Д

2022.03.15 № 1302/441

танай ________ -ны № ________ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Завхан АЗЗА -ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Завхан АЗЗА -ТӨХК-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*Аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас давсан, 2021 оны байгууллагын үйл ажиллагааг алдагдалтай тайлагнасан, НӨАТ-ын болон , ХХОАТ, албан хаагчдад өгөх цалингийн өглөг өссөн, цалингийн зардал, захиргаа удирдлагын зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан, Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага /АТГ -хянагдаж байгаа/ бүртгээгүй, Уулс -дөл ХХК-аас авах 2020 оны санхүүгийн тайлангаар гарсан авлагыг барагдуулаагүй, үйлчилгээний автомашин худалдан авахаар шилжүүлсэн хөрөнгийг авлага үүсгээгүй урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн, конторын засварын зардлыг урьдчилж гарсан зардлар бүртгэсэн, хөрөнгө бэлтгэсэн, тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгслийн тооллогын бүртгэлийг илүү илэрхийлсэн, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсгийн хуурамчаар зурж гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай уулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн*

*16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах “гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 129,718,137.59 | 45,074,158.95 |
| 1.1.2 | Дансны авлага | 75,864,311.07 | 15,038,630.01 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | | |
| 1.1.4 | Бусад авлага | 7,137,100.33 | 187,775,435.21 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 384,016,330.76 | 166,193,108.51 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | 33,830,250 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | | | |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | 1,172,430,518.53 | 1,110,157,948.12 |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | 1,692,736,054,33 | 1,172,430,518,53 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,075,522,397.32 | 1,014,461,948.12 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 96,908,121.21 | 95,696,000 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | | |
| 1.2.4 | Урт хугацаатхөрөнгө оруулалт | | |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | | | |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | 85,846,941.50 | 78,408,202.82 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 48,934,398.19 | 5,873,964.19 |
| 2.1.1.2 | Цалингийнөглөг | | |
| 2.1.1.3 | Татварын өр | 36,912,543.31 | 69,157,291.80 |
| 2.1.1.4 | НДШ - ийнөглөг | | |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүнийөглөг | | |
| 2.1.1.7 | Ногдол ашгийнөглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | | |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | 85,846,941.50 | 78,408,202.82 |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 291,360,199 | 291,360,199 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | | |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.5 | | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | 291,360,199 | 291,360,199 |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | 377,207,140.50 | 369,768,401.82 |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 431,714,192 | 431,714,192 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3.2 | хувийн | | |
| 2.3.3 | хувьцаат | | |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 73,020,780,11 | 73,020,780,11 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 622,638,311,76 | 622,638,311,76 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 264,585,973.91 | 60,927,845.09 |
| 2.3.10 | | | |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | 1,391,959,257.78 | 1,188,301,128.96 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | 1,769,166,398.28 | 1,558,069,530.79 |

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | 1328020526.14 | 965235802.73 |
| 2 | Борлуулалтын өртөг | 1088565013.93 | 999214393.97 |
| **3** | **Нийт ашиг( алдагдал)** | 239455512.21 | -33978591.24 |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | 674248.58 | 0 |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 0 | 50000 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 183375127.56 | 212111460.89 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | 21693111.58 | 4496254.47 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэнолз (гарз) | | |
| **17** | Бусад ашиг ( алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөхашиг( алдагдал)** | 35061521.65 | -250536306.60 |
| **19** | Орлогын татварын зардал | 3698310.47 | 0 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | 31363211.18 | -250536306.60 |
| **21** | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | 31363211.18 | -250536306.60 |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү | | |
| | Бусадолз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | 31363211.18 | -250536306.60 |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1,054,352,503.76 | | 73,020,780,11 | | 233,909,762.73 | 1,361,283,046.60 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 30,676,211.18 | 30,676,211.18 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | | |
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1,054,352,503.76 | | 73,020,780.11 | | 264,585,973.91 | 1,391,959,257.78 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | 50,041,497.79 | 50,041,,497.79 |
| **Залруулсан үлдэгдэл** | 1054352503.76 | | 73020780.11 | | 314,627,471.7 | 1,442,000,755.51 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | (250,536,306.60) | (250,536,306.60) |
| Зарласан ногдол ашиг | | | | | 3,163,320 | 3,163,320 |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1054352503.76 | | 73020780.11 | | 60,927,845.1 | 1,188,301,128.96 |

### .4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйлажиллагаанымөнгөнгүйлгээ | 2,219,588,866.99 | 1,134,669,383 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 2,219,588,866.99 | 1,134,669,383 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,270,026,044.32 | 982,872,808.23 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| | Буцаан авсан албан татвар | | |
| | Татаас, санхүүжилтийн орлого | | |
| | Бусад мөнгөн орлого | 949,562,822.67 | 151,796,574.77 |
| 1.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | 641,696,091.11 | 1,141,572,850.64 |
| | Ажиллагчдад төлсөн | 297,624,650.15 | 294,540,803 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 87,118,717.26 | 100,269,881.07 |
| | Бараа материал худалданавахад төлсөн | 56,212,636 | 153,892,790 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 4,807,486 | 6,465,830.53 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлдтөлсөн | 99,622,766 | 334,912,326.72 |
| | Хүүний төлбөрт төлсөн | 185,630 | |
| | Татварын байгууллагад төлсөн | 96,897,664.80 | 61,618,269.53 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | | 576,000 |
| | Бусад мөнгөн зарлага | 7,439,824.85 | 189,296,949.79 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 1,569,679,491.93 | (6,903,467.64) |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 674,248.58 | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 674,248.58 | |

| | | | |
|---|---|---|---|
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 674,248.58 | |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | 2,632,250 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 674,248.58 | |
| | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| | | | |
| 2.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | 13,389,800 | 31,002,700 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 3,159,800 | 26,538,900 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 10,230,000 | 4,463,800 |
| | | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн | | (28,370,450) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | (49,370,061) |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | 100,000,000 |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| | Төрөл бүрийн хандив | | |
| 3.2 | Мөнгөнзарлагын дүн (-) | 1,430,599,929.20 | 149,370,061 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 1,429,912,929.20 | 146,206,741 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | | |
| | Төлсөн ногдол ашиг | 687,000 | 3,163,320 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн | 1,430,599,929.20 | 49,370,061 |
| **4** | Валютын ханшийн зөрүү | | |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | 126,364,011.31 | ( 84,643,978.64) |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,354,126.28 | 129,718,137.59 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 129,718,137.59 | 45,074,158.95 |

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/төгрөг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| A | Нийт орлого | мян | 1,328,020,694,700 | 1,395,875000 | 965,285,800 | (430,589,200) | 69.2 |
| 1 | Үүнээс: Улсын чанартай ЗЗ Ажил | мян | 1,155,713,100 | 1,192,077000 | 759,095,700 | (432,981,300) | 63.7 |
| 2 | Бусад | мян | 172,307,300 | 203798000 | 206190100 | 2,392,100 | 101.2 |
| **3** | **Нийт зардал** | **мян** | **1,293,633,200** | **1206891900** | **1215822100** | **8,930,200** | **100.7** |
| 4 | Татварын өмнөх ашиг | мян | 35,061,500 | 188,983,100 | (250,536,306.60) | (43,951,9400) | (132.6 |
| 5 | Цэвэр ашиг /алдагдал | мян | 31,363,200 | 170,084,800 | (250,536,300) | (170,084,800) | - |
| 6 | Төсвийн төлбөрт | мян | 246,595,500 | 156,468,000 | 186,340,700 | 29,872,700 | 119.1 |
| 7 | Төрийн өмчийн ноогдол ашиг | мян | 4,673,100 | 25,512,700 | 11,883,000 | (13,629,700) | 46.6 |
| (8 | Нийт авлага | мян | 83,001,400 | 96,432,000 | 202,814,000 | 106,382,000 | 210.3 |
| 9 | Нийт өглөг | мян | 377,207,100 | 328,514,300 | 36,9768,400 | 41,254,100 | 112.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Үүнээс : Богино хугацаат | мян | 85,846,900 | 32,154,300 | 784,082,003 | 46,253,900 | 243.8 |
| | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мян | 0.97 | 0,86 | 1.02 | 0.2 | 0,002 |
| 11 | Хөрөнгө оруулалт | мян | 68,467,000 | 185,000,000 | 3,399,000 | (184,996,100) | 147.2 4 |
| 12 | Ажиллагсдын тоо | хүн | 37 | 37 | 37 | | 100 |
| 13 | Цалингийн сан | мян | 335,501,600 | 334,364,300 | 364,668,100 | 30,303,800 | 109.1 |
| 14 | Нэг ажилтаны дундаж цалин | мян | 755,600 | 778,800 | 821,300 | 42,500 | 105.5 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан АЗЗА -ТӨХК-ы 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн үйл ажиллагааны алдагдал, авлага, өглөг, залруулсан алдаа, хөрөнгө бэлтгэх болон бусад асуудлаар шаардлагын хэмжээнд хүрээгүй талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан АЗЗА -ТӨХК-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 03 дүгээр сарын 04-ны өдрийн 19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Завхан АЗЗА ТӨХК нь 4 чиглэлийн улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлыг гүйцэтгэж замын бэлэн байдлынг ханган ажиллахын зэрэгцээ авто замын гүүрийн арчлалт засвар өргөтгөл барих, орон нутгийн зам засварын ажлыг гүйцэтгэх, зам барилгын ажил болон тохижилтын ажил хийх тендерт оролцон нийт 1395,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх зорилготой

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр үр нөлөөгүй байна.

Тухайлбал: 2020,2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд мэдээллийн дагуу Улаанбаатар хотын Мэдээлэл аудитын аудиторууд хөндлөнгийн шинжээч, улсын магадлагчаар орж байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалтыг хийж зөвлөмж хүргүүлсэн мөн, зарим нэг асуудал АТГ-дээр хянагдаж эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Завхан АЗЗА -ТӨХК-ын -ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “ИХ” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар авч үзэхэд ТУЗ-ын дотоод аудит ажиллаагүй, хяналтын талаар хийсэн ажлын тайлан байхгүй, байгууллагын дотоод аудит хяналтын ажлыг гүйцэтгээгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан АЗЗА -ТӨХК-ын -ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

**3.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “ИХ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгө 1,558,069.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 31161,4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24929,1 мянган төгрөгөөр тогтоосон.

**3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 129,718,137.59 | 45,074,158.95 | -84643978.64 |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 83001411.4 | 202814065.22 | 119812653.82 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 384016330.76 | 166193108.51 | -217823222.25 |
| Үндсэн хөрөнгө | 1172430518.53 | 1110157948.12 | -<br>62272570.41 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1769166398.28** | **1558069530.79** | **-211096867.49** |
| Өр төлбөр | 377207140.50 | 369768401.82 | -7438738.68 |
| Эздийн өмч | 1391959257.78 | 1188301128.96 | -203658128.82 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **176916398.28** | **1558069530.79** | **-211093867.49** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 84,643.9 мянган төгрөгөөр сая төгрөг буурсан энэ дараа зарцуулагдах зардлын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 119,812.6 сая төгрөг болж өссөн нь Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага /АТГ -хянагдаж байгаа/ 175,195.2 мянган төгрөгөөр тусгагдсан нь нөлөөлсөн.

Мөн Уулс -дөл ХХК-аас авах 2020 оны санхүүгийн тайлангаар гарсан 15,038.6мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, ажилчдаас авах авлага 5,758.3 мянган төгрөг, хувь хүнээс авах авлага 6,857.4 мянган төгрөгийн авлага

Урьдчилж гарсан зардал дансаар 22,800.0 мянган төгрөгийг прус -30 автомашин авахаар төлсөн, мөн ажилчдын ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор гадна дотор цэвэр бохирын шугам шинээр гаргах болон “оо”-ын өрөө шинээр гаргаж тохижуулах ажилд 10,629.4 мянган төгрөгийг үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлж материал бэлдэхэд зарцуулж урьдчилж төлсөн, ажилчдаас 400.8 мянган төгрөгийн хоолны мөнгөний урьдчилгааг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 217,823,2 мянган төгрөгөөр буурсан зам засварын ажлын орлого буурсан нөгөө талаас өмнөх оны үлдэгдэл материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 62,272.5 мянган төгрөгөөр буурсан тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,438.7 мянган төгрөгөөр өглөг буурсан Нийт өглөгийн, НӨАТ болон ХХОАТ-ийн өглөг 69,157.2 мянган төгрөг, ажилчдад цалингийн өглөг 3,376.9 мянган төгрөг ээлж байна.

Мөн Урт хугацаат өглөгт 291,3 сая Кувейтийн сангийн уртын зээл хүлээгдэж нийт 369,768.4 мянган төгрөг богино хугацаат өглөгүүд бүрэн барагдах боломжтой өглөг, авлагууд тооцоо нийлсэн актуудаар баталгаажсан байна.

**Өр үүсдэг шалтгаан: У**лсын чанартай авто замыг цагийн 4 улиралд найдвартай бэлэн байдалд арчилж хамгаалах үүрэг хүлээдэг учир гэнэтийн цас үер усны ажил гардагтай холбоотойгоор тооцоологүй өр үүсдэг.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 203,658.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал 250,536.3 мянган төгрөг, ноогдол ашигт 3,163.3 мянган төгрөг төлсөн нь шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 264,585.9 мянган төгрөг байснаас залруулгаар 50,041.4 мянган төгрөг нэмэгдэж тайлант оны алдагдал, ноогдол ашиг тооцогдож хуримтлагдсан ашиг дансны эцсийн үлдэгдэл 60,927.8 мянган төгрөг болсон байна.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Завхан АЗЗА -ТӨХК-ын -ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны 03 тоот тогтоолоор 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1395,8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1192,0 мянган төгрөгөөр, ашиг / алдагдал -ыг 170084,8 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 185,0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 170,084.8 мянган төгрөгийн ашигтай баталсан бөгөөд 2021 оны үйл ажиллагаа буюу санхүүгийн тайлангаар 250,536.3 мянган төгрөгийн алдагдалтай гарсан.

Дээрхи байдалтай уялдуулан 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хэт өөдрөгөөр дараа жилийн нөхцөл байдлуудыг харгалзан үзэлгүй өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн өндөр төлөвлөсөн байна.

Завхан АЗЗА -ТӨХК-ын -ийн Гүйцэтгэлээр Улсын чанартай зам засварын арчлалтаар 898,799.0 мянган төгрөг, Гэнэтийн замын эвдрэл ,цасны онцгой нөхцөлөөр хийсэн 225,388.3 мянган төгрөгийн, замын хөдөлгөөний эрчимийн тооллогоор 1,365.9 мянган төгрөгийн нийт 1,125.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс 965,235.8 мянган төгрөгийн цэвэр борлуулалттай ажиллан 1,215,822.1 мянган төгрөгийн зардал гарган 250,536.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 1. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| A | Нийт орлого | мян | 1,328,020,694,700 | 1,395,875000 | 965,285,800 | (430,589,200) | 69.2 |
| 1 | Үүнээс: Улсын чанартай ЗЗ Ажил | мян | 1,155,713,100 | 1,192,077000 | 759,095,700 | (432,981,300) | 63.7 |
| 2 | Бусад | мян | 172,307,300 | 203798000 | 206190100 | 2,392,100 | 101.2 |
| **3** | **Нийт зардал** | **мян** | **1,293,633,200** | **1206891900** | **1215822100** | **8,930,200** | **100.7** |
| 4 | Татварын өмнөх ашиг | мян | 35,061,500 | 188,983,100 | (250,536,306.60) | (43,951,9400) | (132.6 |
| 5 | Цэвэр ашиг /алдагдал | мян | 31,363,200 | 170,084,800 | (250,536,300) | (170,084,800) | - |
| 6 | Төсвийн төлбөрт | мян | 246,595,500 | 156,468,000 | 186,340,700 | 29,872,700 | 119.1 |
| 7 | Төрийн өмчийн ноогдол ашиг | мян | 4,673,100 | 25,512,700 | 11,883,000 | (13,629,700) | 46.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| (8 | Нийт авлага | мян | 83,001,400 | 96,432,000 | 202,814,000 | 106,382,000 | 210.3 |
| 9 | Нийт өглөг | мян | 377,207,100 | 328,514,300 | 36,9768,400 | 41,254,100 | 112.6 |
| 10 | Үүнээс : Богино хугацаат | мян | 85,846,900 | 32,154,300 | 784,082,003 | 46,253,900 | 243.8 |
| | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | мян | 0.97 | 0,86 | 1.02 | 0.2 | 0,002 |
| 11 | Хөрөнгө оруулалт | мян | 68,467,000 | 185,000,000 | 3,399,000 | (184,996,100) | 147.24 |
| 12 | Ажиллагсдын тоо | хүн | 37 | 37 | 37 | | 100 |
| 13 | Цалингийн сан | мян | 335,501,600 | 334,364,300 | 364,668,100 | 30,303,800 | 109.1 |
| 14 | Нэг ажилтаны дундаж цалин | мян | 755,600 | 778,800 | 821,300 | 42,500 | 105.5 |

Нийт цэвэр орлогыг 1395,875,0 мянган төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 965,285,8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 430,589,2 мянган төгрөг буюу 31 хувиар буурсан байна.Орлого тасарсан шалтгаан нь нь төлөвлөгөөг өндөр төлөвлөсөн гэж үзэх үндэстэй байна.

2021 онд ТӨБЗГ-ын 315 тогтоолоор төрийн сангийн 100900000702 тоот лансанд 3,163.2 мянган төгрөгийг ногдол ашигт төвлөрүүлсэн байна.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч , хараат бус 2, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 6 удаа зохион байгуулж 5.асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2021 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 27,708.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 26,864.8 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд нийт 169 мэдээлэл оруулахаас 154 мэдээллийг хугацаанд нь оруулж 15 ш мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.Энэ нь тухай бүр концесоор ажил үйлчилгээ хийгдээгүй болохоор шилэн дансыг хугацаа хоцроож оруулсан байна

Шилэн дансны хэрэгжилтийг аудитын явцад тулган шалгах боломжгүй сайт нээгдэхгүй алдаа заасан тул мэдээллийг оруулах боломжгүй байна

### 3.9. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай /*бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт*/ нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.1. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалт бүхий зөвлөмж өгөгдөж, 50 хувиар хэрэгжүүлэн , зээлийн асуудлаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй 100,0 сая төгрөгийн зээл авч хүүгийн зардалд 5700.0 мянган төгрөгийг төлсөн байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн

Завсрын аудит хийгдээгүй

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2021 оны байгууллагын үйл ажиллагааг 250,536,300.00 төгрөгөөр алдагдалтай тайлагнасанд дүгнэлт хийж захиргааны болон цалин, бусад урсгал зардлыг хяналттай зарцуулж үрэлгэн зардал гаргахгүй байх .Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага 175,195,200.00 төгрөг /АТГ -хянагдаж байгаа/ бүртгэгдсэн авлагыг тайланд онд барагдуулж ажиллах талаар тус тус анхаарч ажиллах

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 584,644,530.00 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 584,194,530.00 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 450000 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн. Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага 175,195,200.00 төгрөг /АТГ -хянагдаж байгаа/

### 4.2.1 Залруулсан алдаа:гараагүй

### 4.2 .2 Төлбөрийн акт: тавигдаагүй

### 4.2.3 Албан шаардлага

*<u>Илрүүлэлт:</u>*

Аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас давсан, 2021 оны байгууллагын үйл ажиллагааг 250,536,300.00 төгрөгөөр алдагдалтай тайлагнасан, НӨАТ-ын болон , ХХОАТ, албан хаагчдад өгөх цалингийн өглөг 78,408,200.00 төгрөг болсон, цалингийн зардал, захиргаа удирдлагын зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс 42,303,800.00 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага 175,195,200.00 төгрөг /АТГ -хянагдаж байгаа/ бүртгэгдсэн, Уулс -дөл ХХК-аас авах 2020 оны санхүүгийн тайлангаар гарсан 15,038,630.00 төгрөгийн авлагыг барагдуулаагүй, үйлчилгээний автомашин худалдан авахаар шилжүүлсэн 22,800,000,00 төгрөгийн хөрөнгийг авлага үүсгээгүй урьдчилж гарсан зардлаар бүртэгсэн, конторын засварын 10,629,450.00 төгрөгийг зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн, 3,399,000,00 төгрөгийн хөрөнгө бэлтэгсэн, тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгслийн тооллогын бүртгэлийг илүү илэрхийлсэн, ерөнхий нягтлан бодогчийн гарын үсгийн хуурамчаар зурж гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай уулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах "гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", 23 дугаар зүйлийн 23.1 "Төрийн аудитын байгууллагын хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.2.1.1-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн", 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Байгууллагын үйл ажиллагааг зөв, зохистой удирдаж, орлого , зарлагын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд дүн шинжилгээ хийж үндэстэй төлөвлөн, алдагдлыг бууруулах
2. НӨАТ-ын болон , ХХОАТ, албан хаагчдад өгөх 78,408,200.00 төгрөгийн өглөгийг барагдуулж өр авлагагүй ажиллах
3. Улаанбаатар хот Мэдээлэл аудитын зөвлөмжөөр үүсгэсэн АЗЗА-ТӨХК-ын захирал Б.Санжсүрэнгээс авах авлага 175,195,200.00 төгрөг /АТГ -хянагдаж байгаа/ -ийг холбогдох шийдвэрийг үндэслэн барагдуулж бүртгэлийг эрүүлжүүлэх
4. Уулс -дөл ХХК-аас авах 2020 оны санхүүгийн тайлангаар гарсан 15,038,630.00 төгрөгийн авлагыг тайлант онд бүрэн барагдуулж хөрөнгийг төвлөрүүлэх
5. Үйлчилгээний автомашин худалдан авахаар шилжүүлсэн 22,800,000,00 төгрөгийн хөрөнгийг хүлээн авч хөрөнгийн орлогод бүртгэх
6. Цалингийн зардал, захиргаа удирдлагын зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулдаг, шаардлагагүй орон тоо авч ажиллуулан үрэлгэн зардал гаргадаг байдлыг таслан зогсоох

7. Байгуулагын үйл ажиллагаа болон дотоодын засвар үйлчилгээ, хөрөнгө худалдан авах зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэдэг байдлыг таслан зогсоож, авлагаар бүртгэн тооцоо нийлж хэвших, зөвхөн үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараа онд дамжин хэрэгжих зардлыг дуусаагүй үйлдвэрлэл данс буюу урьдчилгээ дансаар тооцоо хийх
8. ТУЗ-ийн *болон д*отоод аудитын хяналтын үйл ажиллагааг сайжруулан үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж байх;

9. Дээрх зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний дотор гарган Төрийн аудитын газарт ирүүлэхийг Завхан АЗЗА -ТӨХК-ын гүйцэтгэх захирал Г.Баттулга, нягтлан бодогч Ц.Ариунжаргал нарт даалгав.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Илрүүлэлт:*

   Машин тоног төхөөрөмжийн үлдэгдлийг 450000 төгрөгөөр тодруулга болон байдлын тайланд дутуу илэрхийлсэн нь “нийцсэн бөгөөд зохистой байх” “ иж бүрэн байх” батламж мэдэгдүүдтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

   Машин тоног төхөөрөмжийн үлдэгдлийг 450000 төгрөгөөр тодруулга болон байдлын тайланд санхүүгийн тооцоолохтой ярьж үлдэгдлийг зөв болгон хөтөлж бүртгэх

Дээрх зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний дотор гарган Төрийн аудитын газарт ирүүлэхийг Завхан АЗЗА -ТӨХК-ын гүйцэтгэх захирал Г.Баттулга, нягтлан бодогч Ц.Ариунжаргал нарт даалгав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | АЗЗА-ТӨХК | 8 | 584,6 | | | | | 7 | 584,15 | 1 | 0,45 |
| Дүн | | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | |
| Нийт дүн | | 8 | 584,6 | | | | | 7 | 584,15 | 1 | 0,45 |

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Д.БАТ-УНДРАА Огноо: 2021/03/15

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР Б.ЗАЯА Огноо: 2021/03/15

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН Огноо: 2021/03/15